

ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН АУДИТЫН ЗӨВЛӨМЖИЙН МӨРӨӨР АЖИЛЛАСАН АЖЛЫН ТАЙЛАН

2017.10.15

Нэг: Зөвлөмжийн бүртгэлийн талаар:

Төв аймаг дахь Төрийн аудитын газрын 2017 оны 09 дүгээр сарын 30-ны байдлаар гаргасан статистик мэдээнээс харахад гүйцэтгэлийн аудитын 14, нийцлийн аудитын 13 зөвлөмж хэрэгжээгүй он дамжсан боловч 2017 ондоо хэрэгжсэн байна. 2017 оны 9 сарын 30-ны байдлаар санхүүгийн аудитын 499, гүйцэтгэлийн аудитын 19, нийцлийн аудитын 21 зөвлөмж өгсөн байна. Үүнээс 82 зөвлөмж хэрэгжих хугацаа болоогүй байна.

Нийт зөвлөмжийг төрлөөр авч үзвэл дараах байдалтай байна.

№	Аудитын төрөл	Өмнөх оноос шилжиж ирсэн		Тайлант оны												Дараа онд шилжих хэрэгжээгүй зөвлөмжийн үлдэгдэл
				Зөвлөмж /тоо/						Үүнээс: хэрэгжүүлсэн						
		Зөвлөмжийн тоо	Хэрэгжилт	Бүгд	Үүнээс:					Бүгд	Үүнээс:					
					Арвилан хэмнэх, үр ашиг, үр нөлөөг сайжруулах	Бүртгэл тайлагналтай холбоотой	Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой	Дотоод хяналтыг сайжуулах	Бусад		Арвилан хэмнэх, үр ашиг, үр нөлөөг сайжруулах	Бүртгэл тайлагналтай холбоотой	Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой	Дотоод хяналтыг сайжуулах	Бусад	
A	Б	1	7	13	14	15	16	17	18	19	20	21	22	23	24	25=1+13-7-19/
1	Санхүүгийн тайлангийн аудит			499	74	229	134	42	20	449	72	219	103	40	15	50
2	Гүйцэтгэлийн аудит	14	14	19	3	2	7	3	4	5	1		2		2	14
3	Нийцлийн аудит	13	13	21	5	1	11	3	1	3			1	1	1	18
Нийт дүн		27	27	539	82	232	152	48	25	457	73	219	106	41	18	82

Нийт зөвлөмжийг ангилвал: **15.1** хувь нь арвилан хэмнэх, үр ашиг, үр нөлөөг сайжруулах, **43.1** хувь нь бүртгэл тайлагналтай холбоотой, **28.3** хувь нь хууль


тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой, **8.9** хувь нь дотоод хяналтыг сайжруулах, **4.6** хувь нь бусад чиглэлээр өгөгдсөн зөвлөмжүүд байна.



Хоёр: Зөвлөмжийн хэрэгжилтийн талаар

Өмнөх оноос шилжиж ирсэн 27 зөвлөмжийн биелэлтийг гаргаж ирүүлсэн байна.

Тайлант онд нийт 539 зөвлөмж хүргүүлснээс 457 зөвлөмж бүрэн хэрэгжсэн, 82 зөвлөмж хэрэгжих шатандаа буюу хугацаа болоогүй учраас биелэлт ирүүлээгүй байна. Хэрэгжсэн зөвлөмжийг авч үзвэл Санхүүгийн тайлангийн аудитын 449 зөвлөмж хэрэгжсэн, 50 зөвлөмж хэрэгжих шатандаа, Гүйцэтгэлийн аудитын нийт 19 зөвлөмж хүргүүлснээс 5 зөвлөмж хэрэгжсэн, 14 зөвлөмж хэрэгжих хугацаа болоогүй, Нийцлийн аудитын нийт 21 зөвлөмж хүргүүлснээс 3 хэрэгжиж, 18 зөвлөмж хугацаа болоогүй байна. Хоёр, гуравдугаар улиралд хийгдсэн гүйцэтгэл, нийцлийн аудитын зөвлөмжийн хэрэгжилтийг ирүүлэх хугацаа болоогүй байна.



1. Гүйцэтгэлийн аудитын 2017 оны 9 сарын байдлаарх зөвлөмжийн биелэлтийн талаар

2017 оны эхний 9 сарын байдлаар 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу эхний гуравдугаар улиралд ҮАГазрын нэгдсэн удирдамж, төлөвлөгөөгөөр 5, аймгийн ИТХ-ын захиалгаар 2, бүгд 7 гүйцэтгэлийн аудитыг хийж 19 зөвлөмж өгсөн байна.

Нийт хийгдсэн аудитаас 4 аудитад 19 зөвлөмж хүргүүлж биелэлт 26.3%-ийн хэрэгжилттэй байна. Аудит тус бүрээр авч үзвэл:

Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилт, үр дүнд 6, Зарим төсөл хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнд 5, Өмч хувьчлалын орлого бүрдүүлэлтийн байдалд 5, Татварын хөнгөлөлт чөлөөлөлтийн бодлого, түүний хэрэгжилт, үр дүнд 3 зөвлөмжийг тус тус өгсөн байна.

2. Нийцлийн аудитын 2017 оны 9 сарын байдлаарх зөвлөмжийн биелэлтийн талаар

2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу эхний гуравдугаар улиралд ҮАГазрын нэгдсэн удирдамж, төлөвлөгөөгөөр 3, аймгийн ИТХ-ын захиалгаар 2, бүгд 5 нийцлийн аудитыг хийж 21 зөвлөмж өгсөн байна.

Нийт хийгдсэн аудитаас 4 аудитад 21 зөвлөмж хүргүүлж биелэлт 14.2%-ийн хэрэгжилттэй байна. Аудит тус бүрээр авч үзвэл:

Орон нутгийг хөгжүүлэх сангийн зарцуулалтад 5, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн улсын төсвөөс санхүүжүүлэх зардлын гүйцэтгэлд 3, Усны тухай хуулийн хэрэгжилтэд 7, Газрын тухай хуулийн хэрэгжилт 6 зөвлөмжийг тус тус өгсөн байна.

3. Санхүүгийн аудитын аудитаар өгөгдсөн зөвлөмжийн биелэлтийн талаар

Тайлант онд санхүүгийн тайлангийн аудитаар 265 төсөв захирагчтай холбоотой 5079.2 сая төгрөгийн алдаа зөрчилд 499 зөвлөмж өгөгдөж, биелэлт 90%-тай байна.

Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд 27, Төсвийн төвлөрүүлэн захирагчид 52, Төсвийн шууд захирагчид 420 зөвлөмжийг хүргүүлсэн байна.

Гурав: Зөвлөмжийн мөрөөр ажилласан ажлын талаар

Аудитын зөвлөмжийн мөрөөр ажиллах ажлын төлөвлөгөөг 2017.09.27-2017.10.17-ны хугацаанд батлуулан хэрэгжүүлж ажиллаа. Уг төлөвлөгөөнд 7 гүйцэтгэлийн аудит, 6 нийцлийн аудит, 36 санхүүгийн аудитын зөвлөмжийн хэрэгжилтийг 7 аудитор газар дээр нь очиж шалгалт хийлээ.

Гүйцэтгэлийн аудитын хүрээнд:

2017 оны 09 сарын 30-ны байдлаар 9 зөвлөмж 100%, 17 зөвлөмж хэрэгжих шатандаа, 5 зөвлөмж хугацаа болоогүй, 5 зөвлөмж хэрэгжээгүй байна. /Хүснэгтээр хавсаргав./

Нийцлийн аудитын хүрээнд:

2017 оны 09 сарын 30-ны байдлаар нийцлийн аудитын 3 зөвлөмж 100%, 7 зөвлөмж хэрэгжих шатандаа хийгдэж байна. /Хүснэгтээр хавсаргав./

Санхүүгийн аудитын хүрээнд:

2017 оны 09 сарын 30-ны байдлаар аймгийн төвийн байгууллагуудын зөвлөмжийн хэрэгжилтийг газар дээр нь очиж шалгахад 15 байгууллагын зөвлөмж 100%, 12 байгууллагын зөвлөмж 90%, 6 байгууллагын зөвлөмж 80%, 1 байгууллагын зөвлөмж хэрэгжээгүй байна. /Хүснэгтээр хавсаргав./

Дүгнэлт:

2017 оны эхний 9 дүгээр сарын байдлаар 539 зөвлөмжийг хүргүүлсний 82 буюу 15.2 хувь нь 2017 оны 4-р уилралд хэрэгжилт нь гарахаар байна.

2017 оны зөвлөмжийн хэрэгжилтийг дүгнэх бүрэн боломжгүй байгаа тул оны эцэст давтан шалгах, зөвлөмжийн хэрэгжилтийг тогтоосон хугацаанд ирүүлээгүй албан тушаалтанд хуульд заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулах саналыг холбогдох албан тушаалтанд хүргүүлэх тухай албан бичгийг оны эцэст хүргүүлэхээр төлөвлөж байна.

Тайлан бичсэн. Аудитын менежер О.Амаржаргал

Хянасан: Дарга, Тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал